

ХЯЗГААРЛАГДМАЛ ОРЧНЫ АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЗААВАР (төсөл 2021.03.19)

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Энэхүү заавар нь ажилтан хязгаарлагдмал орчинд нэвтрэн ажиллах үед тэдний хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийг хамгаалах зорилготой.

1.2 Энэхүү зааврыг боловсруулахад Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 6.1, 7.1, 7.2 дугаар зүйлийг үндэслэл болгов.

1.3 Энэхүү зааврыг хязгаарлагдмал орчин бүхий ажлын байртай ажил олгогч мөрдөнө. Далд уурхайн ажлын байр, аврах ажиллгаанд мөрдөхгүй.

1.4 Зааврын хэрэгжилтийг аж ахуйн нэгж байгууллагын ХАБЭА-н ажилтан хариуцаж ажиллана. Уг ажилтан нь хязгаарлагдмал орчны аюулгүй ажиллагаагаар мэргэшсэн байна.

1.5 Аж ахуйн нэгж байгууллага буюу ажил олгогч нь энэхүү зааврыг хэрэгжүүлэхэд менежментийн дэмжлэгээр хангах, зардлыг төсөвлөж, зарцуулна.

Хоёр. Нэршил тодорхойлолт

2.1 Хязгаарлагдмал орчин

Хүн байнга ажиллахад зориулагдаагүй, орц, гарц нь чөлөөтэй бус, агаар сэлгэлт хангалтгүй хагас эсвэл бүтэн хаалттай орчныг хэлнэ. Хязгаарлагдмал орчинд цонх агааржуулалтгүй тасалгаа, шингэн болон хуурай материал хадгалах нөөцлүүр сав, дулаан, хий, ус, бохир дамжуулах шугам хоолойн худаг, (траншей), тогоо, шугам, утаа, агаар дамжуулах яндан хоолой, халаалтын зуух, нүүрснээс хий ялгах зуух, баяжуулах үйлдвэрийн болон уурхайн томоохон төхөөрөмжүүдийн хоолой хийцүүд, төмөрлөгийн үйлдвэрийн шанага, зуух хийцүүд, цахилгааны өвөрмөц хийцтэй цуглуулга хайрцаг, бусад төрлийн хагас эсвэл бүтэн хаалттай орчин хамаарна. Хязгаарлагдмал орчин нь дараах аюултай нөхцөлийг үүсгэдэг. Үүнд:

- a) Ажилтанд хордлого үүсгэх, галын эсвэл тэсэрч дэлбэрэх аюултай, хортой химийн бодисын хий, уур, даралттай хий, дулааны цохилт, тоосонцор агуулагдах боломжтой,
- b) Хүн хэвийн амьсгалахад сөргөөр нөлөөлөх эсвэл агааржуулалт хангалтгүйн улмаас амьсгалын дутагдалд хүргэх, гэнэтийн хийн ялгаралд хордох,
- c) Ажилтныг ажиллах үед живүүлэх эсвэл сорох, дарагдах, хавчигдах аюултай материал агуулсан.
- d) Хэт хүйтэн орчинд хөдөлгөөний сааралт үүсэх, осгох, хөлдөх

Энэхүү зааврын 5.1-5.7-д заасны дагуу үнэлгээ хийж хязгаарлагдмал орчныг тодорхойлно.

2.2 Хязгаарлагдмал орчныг бүртгэл

Аж ахуйн нэгж байгууллага энэхүү зааврын 5.1-5.7-д заасны дагуу өөрийн эзэмшлийн эсвэл түр ашигладаг барилга байгууламж, дэд бүтцэд үнэлгээ хийж, хязгаарлагдмал орчныг тодорхойлон бүртгэж авах, тэмдэг тэмдэглэгээжүүлэх үйл явц.

2.3 Эрсдэлийн үнэлгээ

Хязгаарлагдмал орчинд ажилтан нэвтрэхээс өмнө тухайн орчноос ажилтны аюулгүй байдал, эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх аюулыг илрүүлэх, тохиолдож болзошгүй эрсдэлийг үнэлэх, түүнийг арилгах, бууруулах арга хэмжээг тодорхойлох үйл ажиллагаа.

2.4 Агаарын чанарын хэмжилт

Эрсдлийн үнэлгээний хүрээнд болон хязгаарлагдмал орчинд ажил гүйцэтгэх явцад агаар дахь хүчилтөрөгч, шатамхай, хорт хийнүүдийн концентрацийг зориулалтыг багажаар хэмжиж, эрүүл мэнд, аюулгүй байдлын шаардлага хангаж буй эсэхэд хяналт тавих үйл явц.

2.5 Хязгаарлагдмал орчинд нэвтрэх

Эрх бүхийн ХАБЭА-н ажилтны олгосон зөвшөөрлийн дагуу ажилтан толгой эсвэл бүх биеэрээ хязгаарлагдмал орчинд нэвтрэх үйл явц

2.6 Хязгаарлагдал орчинд нэвтрэх зөвшөөрөл

Хязгаарлагдмал орчноос ажилтны амь нас, эрүүл мэндэд учирж болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор эрсдэлийн үнэлгээнд үндэслэн олгодог бичгээр үйлдсэн зөвшөөрөл.

2.7 Эрх бүхий удирдах ажилтан

Хязгаарлагдмал орчны аюулгүй ажиллагааг энэхүү зааврын шаардлагад нийцүүлэн удирдан зохион байгуулж, хязгаарлагдал орчинд нэвтрэх зөвшөөрлийг олгох, эрх бүхий ХАБЭА-н ажилтныг мэргэжлийн арга зүй, менежментийн дэмжлэгээр ханган ажиллах ХАБЭА-н эрх бүхий удирдах албан тушаалтан. Эрх бүхий удирдах ажилтан нь мэргэжлийн байгууллагаас зохион байгуулсан сургалтад хамрагдаж хязгаарлагдмал орчны аюулгүй ажиллагаагаар мэргэшсэн байна.

2.8 Эрх бүхий ХАБЭА-н ажилтан

Энэхүү зааварт нийцүүлсэн хязгаарлагдмал орчны аюулгүй ажиллагааг журмын хэрэгжилтийг хариуцан ажиллах, ажилтнуудын үүргийн биелэлт, ажлын үйл явц, аюулгүй ажиллагаанд хяналт тавих эрх бүхий ХАБЭА-н албан тушаалтан. Эрх бүхий ХАБЭА-н ажилтан нь мэргэжлийн байгууллагаас зохион байгуулсан сургалтад хамрагдаж хязгаарлагдмал орчны аюулгүй ажиллагаагаар мэргэшсэн байна.

2.9 Ахлах ажилтан

Хязгаарлагдмал орчинд зайлшгүй нэвтрэн ажил гүйцэтгэх шаардлагатай хэлтэс нэгжийн удирдах түвшний ажилтан. Ахлах ажилтан нь хязгаарлагдмал орчны аюулгүй ажиллагааны сургалтад хамрагдсан, үндсэн ажил үүргээ гүйцэтгэх талаар багийн ажилтнууддаа мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх чадамжийг эзэмшсэн байна.

2.10 Нэвтрэгч ажилтан

Эрх бүхий ХАБЭА-н ажилтнаас олгосон зөвшөөрлийн дагуу хязгаарлагдмал орчинд нэвтэрч ажил үүргээ аюулгүй гүйцэтгэх чадамжтай ажилтан. Нэвтрэгч ажилтан нь хязгаарлагдмал орчны аюулгүй ажиллагааны сургалтад хамрагдсан, үндсэн ажил үүргээ хангалттай түвшинд гүйцэтгэх чадамжтай байна.

2.11 Хянагч ажилтан

Эрх бүхий удирдах ажилтнаас олгосон зөвшөөрлийн дагуу хязгаарлагдмал орчинд нэвтэрсэн ажилтныг дагалдаж, аюулгүй байдалд ажиглалт хийх, тусалцаа үзүүлэх, шаардлагатай нөхцөлд ослын үеийн бэлэн байдлын төлөвлөгөө хэрэгжүүлэх ажилтан. Хянагч ажилтан нь хязгаарлагдмал орчны аюулгүй ажиллагааны сургалтад хамрагдсан, үндсэн ажил үүргээ хангалттай түвшинд гүйцэтгэх чадамжтай байна.

Гурав. Ерөнхий шаардлага

3.1 Аж ахуйн нэгж байгууллага нь өөрийн эзэмшлийн эсвэл түр ашигладаг барилга байгууламж, дэд бүтцэд хамаарах байнгын хязгаарлагдмал орчныг нэг бүрчлэн бүртгэж,

аюулыг анхааруулсан, зөвшөөрөлгүй хүмүүс орохоос сэргийлсэн тэмдэг тэмдэглэгээ байрлуулж, шаардлагатай хаалт хашилтаар хангана.

3.2 Хязгаарлагдмал орчинтой ажлын байртай аж ахуйн нэгж байгууллага нь хязгаарлагдмал орчны аюулгүй ажиллагаа хариуцсан эрх бүхий удирдах ажилтныг томилж ажиллуулна. Эрх бүхий удирдах ажилтан нь байгууллагын түвшинд хязгаарлагдмал орчны аюулгүй ажиллагааг энэхүү зааврын шаардлагад нийцүүлэн удирдан зохион байгуулна.

3.3 Хязгаарлагдмал орчинд аливаа ажил гүйцэтгэхээс өмнө энэхүү зааврын дагуу эрсдэлийн үнэлгээ хийж, аюулгүй нь тогтоогдсон эсвэл эрсдэлийг хангалттай түвшинд бууруулсан тохиолдолд ажилтанд нэвтрэх зөвшөөрөл олгоно.

3.4 Хязгаарлагдмал орчинд нэвтрэх зөвшөөрөл олгохсон байдал, түүнд нэвтрэн ажиллаж буй ажилтнуудын тухайн ажлын байрны онцлогт тохирсон сургалт зааварчилгаа өгөх, аюулгүй ажиллагаанд хяналт тавих асуудлыг эрх бүхий ХАБЭА-н ажилтан хариуцна.

3.5 Хязгаарлагдмал орчинд нэвтрэн ажил гүйцэтгэдэг аж ахуйн нэгж байгууллага нь ослын үед хэрэгжүүлэх аврах ажиллагааны төлөвлөгөөтэй, төлөвлөгөөнийхөө дагуу дасгал сургуулилт хийх болон түүний бэлэн байдлыг хангасан байна.

3.6 Хязгаарлагдмал орчны аюулгүй ажиллагааг хариуцсан эрх бүхий ХАБЭА-н ажилтан нь хязгаарлагдмал орчны аюулгүй ажиллагааны мэргэшүүлэх сургалтад хамрагдаж, дараах чадамжийг эзэмшсэн байна. Үүнд:

- Хязгаарлагдмал орчныг тодорхойлох,
- Хязгаарлагдмал орчин дахь аюулыг илрүүлэх, эрсдэлийг үнэлэх, удирдах,
- Хязгаарлагдмал орчны агаарын чанарыг хэмжиж, үр дүнд нь дүгнэлт өгөх,
- Хязгаарлагдмал орчинд нэвтрэх ажилтнуудад ХЭМАБ-ын зааварчилгаа өгөх, хяналт тавих,
- Боломжит аврах ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх.
- Онцгой, эрсдэлтэй нөхцөлд аврах багтай хамтран ажиллах

3.7 Эрх бүхий ХАБЭА-н ажилтан нь энэхүү зааврыг хэрэгжүүлэхдээ дараах талуудтай хамтран ажиллана.

- Эрх бүхий удирдах ажилтан,
- Хязгаарлагдмал орчинд нэвтрэн ажил гүйцэтгэх хэлтэс нэгжийн удирдах (ахлах) ажилтан,
- Хязгаарлагдмал орчинд нэвтрэгч ажилтан,
- Хязгаарлагдмал орчны хянагч ажилтан
- Аврах ажилтан,
- Бусад шаардлагатай холбогдох талуудтай хамтран ажиллана.

3.8 Аж ахуйн нэгж байгууллага нь хязгаарлагдмал орчны аюулгүй ажиллагаа хариуцсан эрх бүхийн ХАБЭА-н ажилтнаа агаарын чанарын хэмжилтийн хий илрүүлэгч (газ детектор) багажаар хангана.

3.9 ХАБЭА-н ажилтангүй, хязгаарлагдмал орчинтой жижиг аж ахуйн нэгж, байгууллага нь энэхүү зааврын шаардлагыг хангасан мэргэжилтэн эсвэл мэргэжлийн байгууллагаар хязгаарлагдмал орчныг тодорхойлох үнэлгээ, эрсдэлийн үнэлгээ хийлгэж болно.

3.10 Барилга байгууламж эзэмшигч эсвэл түр ашиглагч нь аливаа хязгаарлагдмал орчны орц, гарцыг ажилтны аюулгүй байдал, эрүүл мэндэд эрсдэл учруулахгүй байхаар төлөвлөж, ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ.

3.11 Нэвтрэгч ажилтан нь хязгаарлагдмал орчинд үндсэн ажил үүргээ өөрийн болон бусдын эрүүл мэнд, аюулгүй байдалд эрсдэл учруулахгүйгээр гүйцэтгэх чадамжтай, мэргэшсэн байна.


3.12 Хязгаарлагдмал орчинд ажил гүйцэтгэдэг багийн ахлах ажилтан нь хязгаарлагдмал орчны аюулгүй ажиллагааны сургалтад хамрагдсан, энэхүү зааврыг хэрэгжүүлэх, багийн ажилтнуудынхаа эрүүл мэнд, аюулгүй байдалд хяналт тавих чадамжтай, мэргэшсэн байна.

3.13 Аж ахуйн нэгж байгууллага нь хязгаарлагдмал орчны тоог хамгийн боломжтой хэмжээнд цөөлөх, бууруулахад чиглэсэн техник зохион байгуулалтын арга хэмжээ авна.

3.14 Эрсдлийн үнэлгээний дүн, эрсдлийн түвшинд үндэслэн хязгаарлагдмал орчинд аюулыг арилгах, эрсдэлийг бууруулах арга хэмжээг төлөвлөж, хэрэгжүүлнэ.

3.15 Хязгаарлагдмал орчны нээлттэй хэсгийн эргэн тойронд хаалт, хашилт, бусад үр нөлөөтэй хамгаалалтыг хийж хүн, эд зүйл унахаас сэргийлж, анхааруулах тэмдэг тэмдэглэгээ байрлуулна.

3.16 Хязгаарлагдмал орчинд зөвшөөрөлгүй нэвтрэхийг хориглоно. Ослын үед тэр орчныг мэддэг, тусгай бэлтгэл сургуулилтаар мэргэшсэн баг аврах ажиллагаа явуулах зорилгоор хязгаарлагдмал орчин руу нэвтрэхэд зөвшөөрөл шаардахгүй.



Зураг 1. Хязгаарлагдмал орчинд ажил гүйцэтгэх дэс дараалал

Дөрөв. Үүрэг хариуцлага

4.1 Энэхүү зааврыг хэрэгжүүлэхэд оролцдог талуудын үүрэг дараах байдлаар тодорхойлогдоно.

4.2 Эрх бүхий удирдах ажилтны үүрэг:

1. Хязгаарлагдмал орчны аюулгүй ажиллагаагаар мэргэшсэн байх,
2. Байгууллагын түвшинд мөрдөх хязгаарлагдмал орчны аюулгүй ажиллагааны дүрэм журмыг энэхүү зааврын шаардлагад нийцүүлэн боловсруулж батлуулах, хэрэгжилтэд хяналт тавих,
3. Хязгаарлагдмал орчны аюулгүй ажиллагааны журмын хэрэгжилтийг хариуцах эрх бүхий ХАБЭА-н ажилтныг томилох саналыг ажил олгогчид гаргах,
4. Эрх бүхий ХАБЭА-н ажилтныг мэргэжил арга зүй, менежментийн дэмжлэгээр хангах,

5. Хязгаарлагдмал орчны аюулгүй ажиллагааны журмын хэрэгжилт, тулгамдсан асуудлуудын талаар ажил олгогчид харилцаж, зохих шийдвэрийг гаргуулах, зардлыг төсөвлөх
6. Хязгаарлагдмал орчинд нэвтрэх зөвшөөрлийг олгох, шаардлагатай тохиолдолд цуцлах,
7. Хязгаарлагдмал орчны онцгой үеийн бэлэн байдлын төлөвлөгөөг батлах, хэрэгжилтэд нь хяналт тавих,
8. Шаардлагатай тохиолдолд хязгаарлагдмал орчинд аврах ажиллагаа явуулах багийг бэлтгэх

4.3 Эрх бүхий ХАБЭА-н ажилтны үүрэг:

1. Хязгаарлагдмал орчны аюулгүй ажиллагааны сургалтад хамрагдаж мэргэшсэн байх,
2. Хязгаарлагдмал орчны аюулгүй ажиллагааны журмын хэрэгжилтийг хангуулах, хяналт тавих,
3. Хязгаарлагдмал орчныг тодорхойлж, бүртгэл хөтлөх, аюулыг анхааруулсан тэмдэг тэмдэглэгээ байрлуулах,
4. Хязгаарлагдмал орчны эрсдэлийн үнэлгээг тухайн ажлын байр хариуцсан мэргэжилтэнтэй хамтран хийж, нэвтрэх зөвшөөрөл олгох эсэх талаарх саналаа эрх бүхий удирдах ажилтнаар хянуулж, батлуулах,
5. Хязгаарлагдмал орчны агаарын чанарын хэмжилт хийж, тэмдэглэл хөтлөх, хэмжилтийн дүнд үндэслэн техник зохион байгуулалтын арга хэмжээг мэргэжлийн ажилтнуудаар гүйцэтгүүлж, хяналт тавих,
6. Агаарын чанарын хэмжилтийн (хий илрүүлэгч) багажны хэвийн ажиллагааг өдөр тутам шалгах, шалгалт тохируулгыг хуваарийн дагуу тогтмол хийлгэх,
7. Эрсдэлийн үнэлгээнд үндэслэн хязгаарлагдмал орчноос үүсэж болзошгүй аюулыг арилгах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, арга хэмжээг төлөвлөх, хэрэгжилтэд нь хяналт тавих,
8. Хязгаарлагдмал орчинд нэвтрэх зөвшөөрлийн маягтыг хөтлөж, эрх бүхий удирдах ажилтнаар хянуулж батлуулах, ажил дууссаны дараа цуцлах,
9. Хязгаарлагдмал орчинд нэвтрэгч, хянагч, ахлах ажилтнуудад зориулан хязгаарлагдмал орчны аюулгүй ажиллагааны сургалтыг ажлын байран дээр нь хийх, чадамжийг нь үнэлэх,
10. Хязгаарлагдмал орчны нэвтрэгч, хянагч, ахлах ажилтнууд энэхүү зааврын 6.1-6.6-д заасан шаардлагуудыг хангаж буй эсэхэд хяналт тавина
11. Хязгаарлагдмал орчинд нэвтрэгч, хянагч ажилтнуудад аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгөх, хэрэгжилтэд нь хяналт тавих,
12. Хязгаарлагдмал орчинд ажиллах ажилтнуудын ажлын хувцас, хувийн хамгаалах хэрэгслийн хэрэгцээг аюул, эрсдэлийн төрлөөс хамааран тодорхойлж, ахлах ажилтанд хүргүүлэх, хангуулах ажлыг зохион байгуулах.
13. Хязгаарлагдмал орчны онцгой байдлын төлөвлөгөөг боловсруулж, эрх бүхий удирдах ажилтнаар батлуулах, бэлэн байдлыг нь хангах,
14. Онцгой байдлын төлөвлөгөөний бэлэн байдлыг хангах сургуулилтыг хуваарийн дагуу эрх бүхий удирдах ажилтантай хамтран хийх,
15. Ослын үед аврах ажиллагааг төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлэх,

4.4 Хязгаарлагдмал орчинд ажиллах багийн ахлах ажилтны үүрэг:

1. Сургалтад хамрагдаж хязгаарлагдмал орчинд аюулгүй ажиллах чадамжийг эзэмшсэн, мэргэшсэн байх,

2. Багийнхаа ажилтнуудад үндсэн ажил үүргээ гүйцэтгэхэд нь мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх чадамжтай байх,
3. Багийнхаа ажилтнуудын үндсэн ажил үүргээ гүйцэтгэх чадамжийг нь үнэлэх,
4. Хязгаарлагдмал орчинд нэвтрэх эрсдэлийн үнэлгээ хийж, тухайн орчинд нэвтрэхгүйгээр ажил гүйцэтгэх шийдлийг сонгох чадвартай байх,
5. Зайлшгүй шаардлагаар хязгаарлагдмал орчинд нэвтрэх тохиолдолд зөвшөөрөл авах хүсэлтийг энэхүү зааврын дагуу эрх бүхий удирдах ажилтанд гаргах,
6. Зөвшөөрлийн дагуу хязгаарлагдмал орчинд нэвтрэх багийг ахлах, бэлтгэлийг хангуулах, зөвлөж чиглүүлэх, аюулгүй ажиллагаанд нь хяналт тавих,
7. Хязгаарлагдмал орчинд нэвтрэх зөвшөөрлийг орох хэсэгт байрлуулж, ажил гүйцэтгэж дууссаны дараа бүх ажилтан гарсан эсэхийг шалгаж, нэвтрэх зөвшөөрлийг цуцлуулах хүсэлтийг эрх бүхий удирдах ажилтанд гаргах,
8. Хязгаарлагдмал орчноос үүсэж болзошгүй аюулыг арилгах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэхэд эрх бүхий ХАБЭА-н ажилтантай хамтран ажиллах,
9. Эрх бүхий ХАБЭА-н ажилтны тодорхойлсны дагуу хязгаарлагдмал орчинд ажиллах ажилтнуудыг ажлын хувцас, хувийн хамгаалах хэрэгслийг зөв хэрэглүүлэх,
10. Эрсдэлтэй нөхцөл үүссэн тохиолдолд хязгаарлагдмал орчин дахь ажлыг нэн даруй зогсоох, багийг ажлын байрнаас яаралтай гаргах,
11. Хязгаарлагдмал орчинд осол тохиолдсон, онцгой нөхцөл үүссэн үед онцгой үеийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх,

4.5 Хязгаарлагдмал орчинд нэвтрэгч ажилтны үүрэг:

1. Сургалтад хамрагдаж хязгаарлагдмал орчинд аюулгүй ажиллах чадамжийг эзэмшсэн байх,
2. Хязгаарлагдмал орчинд үндсэн ажил үүргээ гүйцэтгэх чадамжтай байх,
3. Хязгаарлагдмал орчинд ажил гүйцэтгэхэд эрүүл мэндийн хориглох заалтгүй талаарх эмчийн дүгнэлтийг гаргуулсан байх,
4. Зөвхөн зөвшөөрлийн дагуу хязгаарлагдмал орчинд нэвтэрч, ХАБЭА-н журмыг чанд мөрдөж ажиллах,
5. Хязгаарлагдмал орчинд ажиллахдаа тохиромжтой хэлбэрээр хянагч ажилтантай тогтмол холбоотой байж, онцгой нөхцөл байдал үүссэн үед яаралтай мэдэгдэх,
6. Эрх бүхий ХАБЭА-н ажилтны зааврын дагуу агаарт хий илрүүлэгч багажийг зүүж ажиллах, аюулын дохио өгсөн үед хязгаарлагдмал орчноос нэн даруй гарах,
7. Хязгаарлагдмал орчноос үүсэж болзошгүй аюулыг арилгах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөөг мөрдөж ажиллах,
8. Ажлын хувцас, хувийн хамгаалах хэрэгслийг зөв зүүж хэрэглэх,
9. Эрсдэлтэй нөхцөл үүссэн тохиолдолд хязгаарлагдмал орчин дахь ажлаа нэн даруй зогсоож, яаралтай гарах,
10. Осол гарсан, онцгой нөхцөл үүссэн үед онцгой байдлын төлөвлөгөөг мөрдөж ажиллах

4.6 Хязгаарлагдмал орчны хянагч ажилтны үүрэг:

1. Сургалтад хамрагдаж хязгаарлагдмал орчинд аюулгүй ажиллах чадамжийг эзэмшсэн байх,
2. Хязгаарлагдмал орчинд үндсэн ажил үүргээ гүйцэтгэх чадамжийг эзэмшсэн байх,
3. Хязгаарлагдмал орчинд ажил гүйцэтгэхэд эрүүл мэндийн хориглох заалтгүй талаарх эмчийн дүгнэлтийг гаргуулсан байх,

4. Зөвхөн зөвшөөрлийн дагуу хязгаарлагдмал орчны хянагчаар ажиллах,
5. Хязгаарлагдмал орчноос үүсэж болзошгүй аюулыг арилгах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөөг мөрдөж ажиллах,
6. Ажлын хувцас, хувийн хамгаалах хэрэгсэлийг зөв өмсөж зүүж хэрэглэх,
7. Хязгаарлагдмал орчинд нэвтэрсэн ажилтантай тохиромжтой харилцааны хэлбэрээр тогтмол холбоотой ажиллаж, ажиглах, аюулгүй байдалд нь хяналт тавих,
8. Гадаад орчинд эрсдэлтэй нөхцөл үүссэн тохиолдолд хязгаарлагдмал орчин дахь ажилтнуудад нэн даруй мэдэгдэж, яаралтай гаргах, тэдэнд туслах,
9. Осол гарсан, онцгой нөхцөл үүссэн үед онцгой байдлын төлөвлөгөөг мөрдөж ажиллах

4.7 Хязгаарлагдмал орчинд аврах ажиллагаа явуулах ажилтны үүрэг.

1. Мэргэжлийн байгууллагын сургалтад хамрагдаж хязгаарлагдмал орчинд аврах ажиллагаа явуулах чадамжийг эзэмшсэн байх,
2. Осолдогчид анхны тусламж үзүүлэх чадамжийг эзэмшсэн байх,
3. Хязгаарлагдмал орчинд үндсэн ажил үүргээ гүйцэтгэх чадамжийг эзэмшсэн байх,
4. Хязгаарлагдмал орчинд ажил гүйцэтгэхэд эрүүл мэндийн хориглох заалтгүй талаарх эмчийн дүгнэлтийг гаргуулсан байх,
5. Аврах ажиллагааны үед ХАБЭА-н дүрэм журмыг чанд мөрдөж ажиллах,
6. Амьсгалын аппарат, бусад хувийн хамгаалах хувцас хэрэгсэлийг зөв хэрэглэх, хамгаалах үр нөлөөг нь шалгах,
7. Аврах ажиллагаанд хэрэглэдэг багаж төхөөрөмжийг зөв, үр нөлөөтэй ашиглах,
8. Аврах ажиллагаанд ашигладаг багаж төхөөрөмжийн бэлэн байдлыг хангах шалгалтыг гүйцэтгэж, тайлан гаргах
9. Анхны тусламжийн иж бүрдэлийн бэлэн байдлыг шалгаж, тэмдэглэл хөтлөх,
10. Аврах ажиллагааны бэлэн байдлыг хангах сургуулилтыг сар тутамд хийх,
11. Тухайн хязгаарлагдмал орчинтой ажлын байруудын байршил, онцлогийг мэдсэн, болзошгүй тохиолдлын үед ажиллах дасгал сургууль хийсэн байх
12. Осол гарсан, онцгой нөхцөл үүссэн үед онцгой байдлын төлөвлөгөөг мөрдөж ажиллах,
13. Онцгой байдлын эрх бүхий байгууллагаас гаргасан дүрэм журмыг мөрдөж ажиллах,

Тав. Хязгаарлагдмал орчны бүртгэл

5.1 Аж ахуйн нэгж байгууллагын эзэмшилд эсвэл түр ашигладаг барилга байгууламж, дэд бүтцэд хамаарах хязгаарлагдмал орчныг тодорхойлох, бүртгэх асуудлыг эрх бүхий ХАБЭА-н ажилтан хариуцана.

5.2 Хязгаарлагдмал орчныг тодорхойлох үнэлгээг дараах дэс дарааллаар хийнэ.

- 1) **Жагсаалт гаргах.** Аж ахуйн нэгж байгууллагын эзэмшлийн эсвэл түр ашигладаг барилга байгууламж, дэд бүтцэд хамаарах хагас болон бүтэн хаалттай бүх орчны жагсаалтыг гаргана.
- 2) **Ажилтан нэвтрэх шаардлага гардаг орчныг сонгох.** Жагсаалтад багтсан хаалттай орчнуудаас ажилтан толгой эсвэл бүх биеэ оруулж ажиллах шаардлагатай орчнуудыг сонгож, үнэлгээг үргэлжлүүлнэ.
- 3) **Аюултай байх магадлалтай орчныг сонгох.** Байнгын ажлын байрны зориулалтаар төлөвлөгдсөн, хангалттай агааржуулалттай, орц, гарц нь чөлөөтэй

хаалттай орчныг үнэлгээнээс хасна. Байнга хүн ажиллахад зориулагдаагүй, орц, гарц нь чөлөөтэй бус, агааржуулалт хангалтгүй орчныг сонгож үнэлгээнд үлдээнээ.

4) **Хязгаарлагдмал орчныг тодорхойлох.** Дээрх шалгуураар сонгосон хаалттай орчнуудаас:

- a. Хортой, шатах, тэсрэх аюултай хий ялгарах, агаар дахь хүчилтөрөгчийн дутагдал (19.5%-иас бага) эсвэл хэт илүүдэл (23.5%-иас их) үүсгэж болзошгүй орчныг хязгаарлагдмал орчинд тооцно.

***Тайлбар:** Маш олон төрлийн нөхцөл байдлын улмаас хязгаарлагдмал орчны агаарт хорт бодис, шатамхай хий ялгарч, хүчилтөрөгчийн хэмжээ аюултай түвшинд хүрдэг. Тухайлбал бохир ус зайлуулах суваг, ус түгээх шугам хоолой, холбооны кабелийн суваг, худаг, нүүрсний гарш зэрэг орчны агаарт хүхэрт устөрөгч, метаны хий хуримтлагдаж, хүчилтөрөгчийн агууламж буурах эрсдэлтэй. Шатахуун, химийн бодис хадгалах, тээвэрлэх савны үлдэгдэл нь дээгдэж тархаснаас хурц хордлого үүсгэх эрсдэлтэй. Худаг, нөөцлүүр сав, агаар сэлгэлтгүй битүү өрөө, давцуу хийц (люк) байгууламжинд гагнуур, будгийн ажил хийх, уусгаагчаар цэвэрлэх үед хорт бодисын их хэмжээгээр ялгардаг.*

- b. Дээрх нөхцөл тодорхойлогдоогүй ч ажилтан ажлаа хийх явцад дарагдах, живэх, гацах, урсах, татагдах, сорогдох гэх мэт аюул үүсэж болзошгүй орчныг хязгаарлагдмал орчинд тооцно.

Хязгаарлагдмал орчныг тодорхойлох үнэлгээний дэс дарааллыг Зураг 2-оор тоймлон үзүүлэв.

5.3 Аж ахуйн нэгж байгууллага нь үнэлгээгээр тодорхойлогдсон хязгаарлагдмал орчныг нэг бүрчлэн бүртгэж, бүртгэл хөтлөнө. Бүртгэлд дараах мэдээллийг агуулвал зохино. Үүнд:


- Хязгаарлагдмал орчны байршил, физик шинж чанарын тодорхойлолт, ялгах дугаар,
- Хязгаарлагдмал орчинд нэвтрэдэг нэгж хэлтэс эсвэл ажилтнууд,
- Хязгаарлагдмал орчныг хариуцагч,
- Хязгаарлагдмал орчинд нэвтрэх зөвшөөрөл олгох албан тушаалтан

5.4 Хязгаарлагдмал орчны гадна аюулыг анхааруулсан тэмдэг, тэмдэглээ байрлуулна. Тэмдэглэгээ нь нэвтрэхийн тулд зөвшөөрөл авсан байх шаардлагатай гэсэн мэдээллийг агуулсан байна. Ойр орчинд ажиллагсад мэдээлэл, ойлголт өгсөн байх шаардлагатай.

5.5 Ажил үүргийнхээ явцад хязгаарлагдмал орчны аюулд өртдөг эсвэл өртөж болзошгүй ажилтнуудад энэ талаарх мэдээллийг өгнө.

5.6 Хязгаарлагдмал орчныг бүртгэлийг жил тутам хянаж, шинэчилнэ.

5.7 Шинээр барилга, дэд бүтэц байгуулах, засвар, өртгөтгөл хийх, үйлдвэрийн тоног төхөөрөмж шинээр суурилуулах бүрт хязгаарлагдмал орчныг тодорхойлох үнэлгээ хийж, бүртгэл хөтөлнө. Аль болохоор хязгаарлагдмал орчинтой ажлын байрын тоог нэмэхгүй байхад анхаарах.



Зураг 2. Хязгаарлагдмал орчныг тодорхойлох үнэлгээний зураглал

Зургаа. Хязгаарлагдмал орчинд ажиллах ажилтанд тавигдах шаардлага

6.1 Хязгаарлагдмал орчинд нэвтрэгч, хянагч, ахлах ажилтан нь дараах шаардлагыг хангасан байна.

- 1) Үндсэн ажил үүргээ гүйцэтгэх ур чадварыг эзэмшсэн, хангалттай туршлага хуримтлуулсан,
- 2) Хязгаарлагдмал орчны аюулгүй ажиллагааны сургалтад хамрагдаж, өөрт болон бусдад эрсдэл учруулахгүйгээр ажиллах, анхны тусламж үзүүлэх чадамжийг эзэмшсэн,

- 3) Эрүүл мэндийн хугацаат үзлэгт хамрагдаж, хязгаарлагдмал орчинд ажиллахад эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны хориглох заалтгүй талаарх эмчийн дүгнэлттэй.

6.2 Нэвтрэгч, хянагч ажилтан үндсэн ажил үүргээ гүйцэтгэх чадамжийг нь ахлах ажилтны хийсэн ур чадварын үнэлгээнд үндэслэн тодорхойлно.

6.3 Нэвтрэгч, хянагч, ахлах ажилтан хязгаарлагдмал орчинд аюулгүй ажиллах чадамжтай эсэхийг нь эрх бүхий ХАБЭА-н ажилтан үнэлгээнд үндэслэн тодорхойлно.

6.4 Аж ахуйн нэгж байгууллага нь хязгаарлагдмал орчинд ажиллах ажилтнаа ЭМС-ын А/340 тоот тушаалын эрүүл мэндийн хугацаат үзлэгт хамруулж, эмчийн дүгнэлт гаргуулсан байна.

6.5 Хязгаарлагдах орчинд зөвхөн “Хүчин төгөлдөр зөвшөөрөлтэй” ажилтан ажиллана. Эрх бүхий ХАБЭА-н ажилтан хязгаарлагдмал орчинд нэвтрэгч, хянагч, ахлах ажилтнуудын нэр, үнэмлэхийг зөвшөөрлийн маягт дээрх мэдээлэлтэй тулгаж шалгана.

6.6 Хязгаарлагдмал орчинд нэвтрэх ажилтан нь шаардлагатай ажлын багаж төхөөрөмж, ажлын хувцас, хувийн хамгаалах хэрэгсэл, харилцаа холбооны хэрэгслээр хангагдсан байна.

Долоо. Хязгаарлагдмал орчинд нэвтрэх зөвшөөрөл

7.1 Ахлах ажилтан зөвшөөрлийн хүсэлт гаргахаас өмнө хязгаарлагдмал орчинд нэвтрэхгүйгээр ажил гүйцэтгэх шийдлийг эрэлхийлж, болзошгүй аюулыг арилгах, эрсдэлээс сэргийлэх арга хэмжээг авна. Хязгаарлагдмал орчинд зайлшгүй нэвтрэх шаардлагатай тохиолдолд зөвшөөрлийн хүсэлт гаргана.

7.2 Хязгаарлагдмал орчинд нэвтрэх зөвшөөрлийн хүсэлтийг ахлах ажилтан эрх бүхий ХАБЭА-н ажилтанд амаар эсвэл бичгээр гаргана.

7.3 Эрх бүхий ХАБЭА-н ажилтан зөвшөөрлийг олгохын өмнө хязгаарлагдмал орчны аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээг хийнэ.

7.4 Эрсдэлийн үнэлгээгээр дараах шаардлагыг хангасан тохиолдолд хязгаарлагдмал орчинд нэвтрэхийг зөвшөөрнө.

- 1) Агаарт агуулагдах хүчилтөрөгчийн түвшин 19.5-23.5%-ийн хооронд байх,
- 2) Агаарт агуулагдах шатамхай хий, уурын түвшин 10% эсвэл тэдгээрийн тэсрэх доод хязгаараас нь бага,
- 3) Агаар дахь хорт бодисын хэмжээ MNS 4990 стандартад заасан зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтрээгүй,
- 4) Хязгаарлагдмал орчин нь ажиллах явцад хангалттай агааржуулалттай,
- 5) Хязгаарлагдмал орчинд ажилтан нэвтрэх үед аюултай хий, уур, хорт бодисын дэгдэлтэд өртөхөөс сэргийлсэн үр нөлөөтэй арга хэмжээг хэрэгжүүлсэн,
- 6) Ажилтны аюулгүй байдал, эрүүл мэндэд эрсдэл учруулж болзошгүй эрсдэлийг бүрэн удирдах, хянах боломжтой,
- 7) Хязгаарлагдмал орчинд нэвтрэх ажилтны аюулгүй байдал, эрүүл мэндийг хамгаалахад чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлсэн.

7.5 Хязгаарлагдмал орчинд нэвтрэгч, хянагч, ахлах ажилтнууд нь энэхүү зааврын 6.1-6.6-д заасан шаардлагыг заасан тохиолдолд зөвшөөрөл олгоно.

7.6 Эрх бүхий удирдах ажилтан дараах мэдээллийг агуулсан хязгаарлагдмал орчинд нэвтрэх зөвшөөрлийн маягтийг 3 хувь хөтлөнө.

- 1) Байгууллагын нэр,
- 2) Нэвтрэх хязгаарлагдмал орчны байршил, тодорхойлолт,
- 3) Хязгаарлагдмал орчинд нэвтрэх зорилго, гүйцэтгэх ажлын тодорхойлолт,
- 4) Хязгаарлагдмал орчинд нэвтрэх зөвшөөрөлтэй ажилтны нэр,
- 5) Хязгаарлагдмал орчинд нэвтрэх ажилтанд хяналт тавих ажилтны нэр,
- 6) Хязгаарлагдмал орчинд нэвтрэх огноо, цаг, минут
- 7) Зөвшөөрөл хүчинтэй хугацаа (ажлын нэг ээлжийн хугацаанаас хэтрэхгүй)
- 8) Агаарын чанарын хэмжилтийн үр дүн,
- 9) Бохирдуулагч болон эрчим хүчний эх үүсвэрийг салгаж тусгаарласан мэдэгдэл,
- 10) Аюулгүй ажиллагааг хангах шаардлагатай арга хэмжээ,
- 11) Ажилтанд өгөх тусгай зааварчилгаа,
- 12) Хязгаарлагдмал орчинд нэвтрэх ажилтныг ажиглаж, харилцах хэлбэр,
- 13) Гэнэтийн ослын үед хэрэгжүүлэх авран хамгаалах төлөвлөгөө,
- 14) Зөвшөөрөл олгосон, хянасан эрх бүхий хүний нэр, гарын үсэг,
- 15) Зөвшөөрлийг хүлээн авсан ахлах ажилтны нэр, гарын үсэг,
- 16) Ажил үүрэг гүйцэтгэж дууссаны дараа ажилтнуудаа бүрэн гаргаж, багаж хэрэгсүүдээ хурааж бүртгэсэн, зөвшөөрлийг цуцалсан эрх бүхий хүний нэр, гарын үсэг

7.7 Эрх бүхий ХАБЭА-н ажилтан нь хөтөлсөн зөвшөөрлийн маягтаа эрх бүхий удирдах ажилтнаар хянуулж, батлуулснаар хүчин төгөлдөр болно.

7.8 Ахлах ажилтан нь зөвшөөрлийг ажил гүйцэтгэх талбайн бүдүүвч зургийн хамт хязгаарлагдмал хэсгийн орох хэсэгт ил байрлуулна.

7.9 Хүчинтэй хугацаа нь дууссан эсвэл нэвтрэгч ажилтан ажлаа дуусаад гарснаар зөвшөөрлийг хүчингүй болгоно. Зөвшөөрөл хүчингүй болгох хүсэлтийг ахлах ажилтан эрх бүхий ХАБЭА-н ажилтанд гаргана.

7.10 Эрх бүхий ХАБЭА-н ажилтан нь зөвшөөрлийг цуцлахаас өмнө дараахыг нягтална.

- 1) Хязгаарлагдмал орчинд орсон бүх хүн гарсныг зөвшөөрлийн маягт дээр гарын үсэг зуруулж баталгаажуулна.
- 2) Хязгаарлагдмал орчинд ажлын багаж, хэрэгсэл үлдээгүй болохыг шалгаж бүртгэн нягтлуулна.

7.11 Хязгаарлагдмал орчинд ХАБЭА-н дүрэм журам зөрчигдсэн, эрсдэлтэй нөхцөл үүссэн тохиолдолд нэвтэрсэн ажилтныг нэн даруй гаргаж, нэвтрэх зөвшөөрлийг хүчингүй болгуулна. Зөвшөөрлийг эрх бүхий ХАБЭА-н ажилтан, эрх бүхий удирдах ажилтан хүчингүй болгон.

7.12 Хязгаарлагдмал орчинд нэвтрэх зөвшөөрлийн 1 хувийг хүсэлт гаргасан ахлах ажилтан, 1 хувийг хянаж, баталсан эрх бүхий удирдах ажилтан хадгална.

7.13 Хязгаарлагдмал орчинд нэвтрэх зөвшөөрлийг 1 жилээс багагүй хугацаагаар хадгална.

Найм. Агаарын чанарын хэмжилт хийгдээгүй хязгаарлагдмал орчинд нэвтрэх зөвшөөрөл

8.1 Хагас задгай, хэвийн агаартай хязгаарлагдмал орчны байранд зөвхөн хэмжилт үнэлгээний эсвэл аврах ажиллагааны зорилгоор агаарын чанарын хэмжилт хийхгүйгээр нэвтрэхийг зөвшөөрнө.

8.2 Хязгаарлагдмал орчны эрсдэлийн үнэлгээ хийх эрх бүхий ХАБЭА-н ажилтан 7.5-д заасан агуулга бүхий маягтын дагуу зөвшөөрөл авах хүсэлтээ эрх бүхий удирдах ажилтанд гаргана.

8.3 Зөвшөөрлийн маягтийн агаарын чанарын хэмжилтийн талаарх тэмдэглэлийг хөтлөхгүй. Бүрэн хязгаарлагдмал орчинд агаарын чанар хэмжихгүйгээр нэвтрэхэд 8.4-д заасан шаардлагыг биелүүлнэ.

8.4 Эрсдэлийн үнэлгээ, хэмжилт хийх зорилгоор хязгаарлагдмал орчинд нэвтрэхэд дараах шаардлагын мөрдөнө.

- 1) Нэвтрэгч ажилтан 6.1-6.6-д заасан шаардлагыг хангасан,
- 2) Ажилтан агаар нөөцлөгчтэй, бүрэн ажиллагаатай амьсгалын аппаратаар хангагдсан, зөв ашиглах чадвартай,
- 3) Эрх бүхий удирдах ажилтны гарын үсэг зурсан хүчинтэй зөвшөөрөлтэй,
- 4) Аюулгүйн бэхэлгээтэй өндөрийн бүс, эсвэл тохиромжой хамгаалах хэрэгслээр тоноглогдсон,
- 5) Хязгаарлагдмал орчны гадна талд байрлаж, онцгой нөхцөлд ажилтныг татаж гаргах эсвэл аврах ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх хянагч ажилтантай байна.

Ес. Хязгаарлагдмал орчны эрсдэлийн үнэлгээ

9.1 Хязгаарлагдмал орчинд нэвтрэх зөвшөөрөл олгохоос өмнө ХАБЭА-н эрх бүхий ажилтан эрсдэлийн үнэлгээ хийнэ. Ийм ажилтангүй байгууллага нь энэ зааврын шаардлагыг хангасан мэргэжлийн байгууллага, мэргэжилтнээр эрсдэлийн үнэлгээ хийлгэж болно.

9.2 Эрсдэлийн үнэлгээ нь хязгаарлагдмал орчин дахь аюулыг илрүүлэх, түүний эх үүсвэр шалтгааныг тодорхойлох, эрсдэлийг арилгах, удирдах тохиромжтой арга хэмжээг төлөвлөж, ажилтанд нэвтрэх зөвшөөрөл олгох эсэх шийдвэр гаргах зорилготой.

9.3 Эрсдэлийн үнэлгээгээр хязгаарлагдмал орчинд үүсэж болзошгүй дараах аюулуудыг ирлүүлнэ. Үүнд:

- Тухайн орчин руу орох, гарах үйлдлийг хязгаарлах саад;
- Агаар дахь хортой хий;
- Агаарын хүчилтөрөгчийн дутагдал;
- Галын аюул (шатамхай хий, хүчилтөрөгчийн илүүдэл, галын эх үүсвэр);
- Хатуу шингэн материалд живэх, бүрхэгдэх;
- Биологийн аюул (вирус, бактери, мөөгөнцөр, харшил-хэт мэдрэгшил үүсгэгч);
- Механик аюул (ажилтны биеийг зүсэх, тасдах, цохих зэргээр гэмтээх);
- Цахилгааны аюул;
- Аюултай бодис ажилтны арьсанд хүрэлцэх аюул;
- Шуугиан, доргионы өртөлт;
- Агаар дахь тоосонцорын өртөлт;
- Хэт халуун температур;
- Дулаан, уурын цохилтонд өртөх;
- Хэт их ус чийг
- Цацраг (ионжуулах болон цахилгаан соронзон цацраг);
- Хангалтгүй гэрэлтүүлэг;

- Гараар гүйцэтгэх ажлаас үүсэх аюул (хүнд зүйл өргөх, албадмал байрлалд ажиллах гэх мэт эргономикийн эрсдэлт хүчин зүйлс);
- Орчны нөхцөлөөс хамаарах бусад аюулууд хамаарна.

9.4 Хязгаарлагдмал орчны онцлог, нөхцөлөөс хамааруулан эрсдэлийн үнэлгээг тохиромжтой аргаар, техник, технологийн онцлогтой уялдуулан хүлээн зөвшөөрөгдсөн дадал практикийн дагуу хийнэ.

9.5 Эрсдэлийн үнэлгээний хүрээнд хязгаарлагдмал орчны агаарын чанарын хэмжилтийг хийнэ. Агаарын чанарын хэмжилтэд 10.1-10.15 хэсэгт заасан шаардлагыг мөрдөнө.

9.6 Эрсдэлийн үнэлгээнээс дараах үр дүн хүлээгдэнэ:

- Эрсдэлийн түвшин,
- Эрсдэлийг арилгах, удирдах арга хэмжээ, түүний үр нөлөөг үнэлэх арга
- Хязгаарлагдмал орчинд нэвтрэх зөвшөөрөл олгох боломжтой эсэх шийдвэр

9.7 Эрсдэлийн үнэлгээ, агаарын чанарын хэмжилтийн үр дүнгээр хязгаарлагдмал орчинд нэвтрэх нь аюулгүй ажиллагаа, эрүүл мэндийн шаардлага хангасан гэж дүгнэвэл эрх бүхий ХАБЭА-н ажилтан нэвтрэх зөвшөөрлийн маягтад гарын үсэг зурж, эрх бүхий удирдах ажилтнаар хянуулж, батлуулна.

Арав. Агаарын чанарын хэмжилт

10.1 Хязгаарлагдмал орчны агаарын чанарын хэмжилтийг ажилтан нэвтрэхээс өмнө эрсдэлийн үнэлгээний хүрээнд хийнэ.

10.2 Хязгаарлагдмал орчны агаарын чанарын хэмжилтийг эрх бүхий ХАБЭА-н ажилтан хийнэ. Уг ажилтан нь 4.6-д заасан шаардлагыг биелүүлж агаарын чанарын хэмжилт хийх, хэмжилтийн багажийг ашиглах чадамжтай байна.

10.3 Хязгаарлагдмал орчны агаарын чанарын хэмжилтийн үр дүн нь зөвхөн тухайн өдрөө хүчинтэй.

10.4 Агаар сорох нэмэлт насос, хоолой(проб)-оор тоноглогдсон хий илрүүлэгч (газ детектор) багажийг ашиглаж, тухайн орчин руу нэвтрэхгүйгээр агаарын чанарын хэмжилт хийнэ.

10.5 Агаарын чанарын хэмжилтээр дараах үзүүлэлтийг тодорхойлно. Үүнд:

- Агаар дахь хүчилтөрөгчийн эзлэх хувь,
- Шатамхай хий, уурны концентраци,
- Тухай орчинд ач холбогдолтой хорт хийн концентраци.

10.6 Хэмжилтийн үр дүн энэхүү зааврын 7.4-д заасан шаардлага хангасан тохиолдолд хязгаарлагдмал орчинд нэвтрэх зөвшөөрлийн маягтад тэмдэглэнэ.

10.7 Хэмжилтийн үр дүн аюулгүй ажиллагаа, эрүүл мэндийн шаардлага хангаагүй тохиолдолд механик агааржуулалтаар хязгаарлагдмал орчны агаарын чанарыг сайжруулах арга хэмжээг хэрэгжүүлж, хэмжилтийг давтаж хийнэ.

10.8 Механик агааржуулалтаар хязгаарлагдмал орчны агаарын чанарыг сайжруулах инженер, технологийн боломжгүй ч тухайн орчинд зайлшгүй нэвтрэх шаардлагатай тохиолдолд агаар хангамжтай амьсгал хамгаалах хэрэгсэл эсвэл агаар нөөцлөгчтэй амьсгалын аппарат хэрэглэнэ. Амьсгал хамгаалах хэрэгсэлийн сонгож, хэрэглэхэд MNS 6654:2017 стандартыг мөрдөнө.

10.9 Ажилтан 30 минутаас удаан хугацаанд хязгаарлагдмал орчинд ажил гүйцэтгэх тохиолдолд агаарын чанарын явцын хэмжилтийг давтамжтай хийж, хяналт тавина.

10.10 Хязгаарлагдмал орчинд нэвтрэгч ажилтанд хий илрүүлэгч багаж(газ детектор) зүүлгэж, явцын хэмжилт хийнэ. Нэг орчинд хоёроос олон хүн ажиллаж байгаа тохиолдолд тэдний төлөөлөл болгож 1-3 хүнд хий илрүүлэгч багаж зүүлгэж болно.

10.11 Хий илрүүлэгч багаж нь шалгалт тохируулга хийгдсэн, ажилтан зүүж хэрэглэхэд тохиромжтой, овор багатай, агаарын чанарын үзүүлэлт аюултай түвшинд хүрэхэд гэрэл, чичиргээ, дуут дохио өгөх боломжтой байна.

10.12 Явцын хэмжилтээр агаарын чанарын үзүүлэлт аюултай түвшинд тодорхойлогдвол, дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ. Үүнд:

- Хязгаарлагдмал орчин дахь бүх ажилтныг нэн даруй гаргах,
- Аюултай нөхцөл нь хэрхэн үүссэн талаарх үнэлгээг хийнэ,
- Хязгаарлагдмал орчны эрсдэлийг дахин үнэлэж, нэвтрэх зөвшөөрлийг эрх бүхий удирдах ажилтан дахин олгох хүртэл ямар ч ажилтныг оруулахгүй.

10.13 Агаарын чанарын явцын хэмжилтийн үр дүнг хязгаарлагдмал орчинд нэвтрэх зөвшөөрлийн маягтад тэмдэглэнэ.

10.14 ХАБЭА-н эрх бүхий ажилтан агаарын чанарын хэмжилтийн багажны хэвийн ажиллагааг өдөр тутам үйлдвэрлэгчийн зааврын дагуу шалгана.

***Тайлбар:** Ихэнх төрлийн хий илрүүлэгч багажны мэдрэгч 2-3 жилийн хугацаанд ашиглах зориулалттай. Тиймээс хий илрүүлэгч багажны мэдрэгчийг дээрх хугацаанд сольж, хэвийн ажиллагааг нь хангах нь зүйтэй.*

10.15 ХАБЭА-н эрх бүхий ажилтан агаарын чанарын хэмжилтийн багажинд хугацаат шалгалт тохируулга хийх хуваарийг гаргаж, 3-6 сар тутамд итгэмжлэгдсэн лаборатори эсвэл үйлдвэрлэгчээс нь зөвшөөрөгдсөн эрх бүхий байгууллагад шалгалт тохируулга хийлгэнэ.

Арван нэг. Хязгаарлагдмал орчны эрүүл ахуй нөхцөл

11.1 Хязгаарлагдах орчинд ажилтан нэвтрэх, ажиллах үед тухайн орчны гэрэлтүүлгийн хэмжээ 100 лк-ээс багагүй байна. Зөөврийн гэрэлтүүлэг ашиглах тохиолдолд энэ нь газардуулгын хамгаалалттай, 32 эсвэл 220 вольтоор ажилладаг байна.

11.2 Хязгаарлагдмал орчинд нэвтрэх, ажиллах үед тухайн орчин дахь тоос, хорт бодис, шатамхай хий, хүчилтөрөгчийн хэмжээ хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэхгүй түвшинд буюу MNS 4990 стандартад заасан зөвшөөрөгдөх хэмжээнд байна.

11.3 Эрсдэлийн үнэлгээгээр хязгаарлагдмал орчинд агааржуулалт хийх шаардлагатай нь тодорхойлогдсон бол дараах ерөнхий шаардлагыг мөрдөнө.

- 1) Агааржуулалт нь ажилтны эрүүл мэнд, аюулгүй байдалд сөрөг нөлөө үзүүлэхээргүй байхаар төлөвлөнө.
- 2) Хязгаарлагдмал орчинд цэвэр агаар оруулах, бохир агаарыг зайлуулахад зөөврийн эсвэл суурин механик агааржуулалтыг ашиглана.
- 3) Механик агааржуулалтаар оруулах агаар нь:
 - а) Тоос, хорт бодис зэрэг аливаа хольц, бохирдолгүй байна.
 - б) Хязгаарлагдал орчин дахь ажилтны байрлаж буй талбай руу агаарын урсгал чиглэнэ.

- 4) Хязгаарлагдмал орчин руу механик агааржуулалтаар агаар оруулах тохиолдолд, бохир агаарыг сорж зайлуулахдаа зөв технологиор гүйцэтгэнэ.
- 5) Механик агааржуулалтын төхөөрөмжийн ажиллагаа, үр нөлөөг тогтмол шалгаж, хэвийн ажиллагаатай байлгана.
- 6) Хязгаарлагдмал орчноос зайлуулж буй бохир агаар нь буцаж тухайн орчин руу орохоос сэргийлж, агаар зайлуулах, агаар оруулах хоолойнуудыг хангалттай хол зайнд байрлуулна.
- 7) Хязгаарлагдмал орчноос соруулсан бохир агаарыг гадна байрлах бусад ажилтнууд, ойр орчмын оршин суугчидад аюулгүй байдлаар зайлуулна.

11.4 Хязгаарлагдмал орчинд гадаад орчныхоос их агаарын даралттай хортой, аюултай бодис хуримтлагдсан байж болзошгүй тул ажилтан нэвтрэхээс өмнө хордлого, ослоос сэргийлж, хязгаарлагдмал орчны тагийг нээж агаарын даралтыг тэнцвэржүүлэх зорилгоор 5 минутаас багагүй хугацаанд хүлээнэ. Үүний дараагаар агаарын чанарын хэмжилт хийж, аюулгүй тохиолдолд нэвтэрнэ.

11.5 Хязгаарлагдмал орчны тагийг нээх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэхэд эрх бүхий ХАБЭА-н ажилтан биечлэн хяналт тавина.

Арван хоёр. Эрсдэлийн удирдлагын ерөнхий зарчим

12.1 Хязгаарлагдмал орчинд тодорхойлогдсон эрсдэлийн шинж чанараас хамаарч тэдгээрийг арилгах, бууруулах тохиромжтой арга хэмжээг хэрэгжүүлнэ.

12.2 Эрсдэлийг арилгах, бууруулах арга хэмжээг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг мөрдөнө.

- 1) Аюулыг арилгах арга хэмжээг нэн тэргүүнд тавьж хязгаарлагдмал орчинд нэвтрэхгүйгээр ажиллах арга шийдлийг сонгоно.
- 2) Хязгаарлагдмал орчинд нэвтрэхээс өөр сонголтгүй, нэвтрэхгүй ажиллах инженер техникийн боломжгүй үед орлуулах, тусгаарлах, инженерийн хяналтыг дангаар нь эсвэл хослуулан хэрэглэнэ.
 - a. **Орлуулах:** Аюултай орчин нөхцөл, багаж төхөөрөмж, арга барилыг аль болох аюулгүйгээр нь орлуулах. Тухайлбал хязгаарлагдмал орчинд ажиллах хугацааг бууруулах нь дулааны стрессэд өртөх магадлалыг бууруулна.
 - b. **Тусгаарлах:** Ажилтан өртөх аюулыг тусгаарлах, салгах байдлаар эрсдэлийг хамгийн бага түвшинд хүргэх. Тухайлбал цахилгаан, эрчим хүчний эх үүсвэрийг тусгаарлах арга байж болно.
 - c. **Инженерийн хяналт:** Эрсдэлийг хамгийн бага түвшинд бууруулах инженер техникийн арга хэмжээ. Тухайлбал худаг, түлшний нөөцлүүр саванд суурилуулсан татах агааржуулалт
- 3) Хязгаарлагдмал орчны нөхцөлд хяналт тавьж эрсдэлээс урьдчилан сэргийлнэ.
 - a. Онцгой нөхцөл үүсэх, аврах ажиллагаа явуулах үед орц, гарцаар нэвтрэх боломжийг нэмэгдүүлэх, ажиллагсад энэ талын мэдлэгтэй байх.
 - b. Орчны бичил цаг уур(температур, чийглэг, агаарын урсгалын хурд)-ын нөхцөлийг хянаж, ажилтан дулааны стресст өртөхөөс сэргийлэх,
 - c. Хангалттай гэрэлтүүлгийг байрлуулж, орчны үзэгдэх байдлыг сайжруулж ослоос сэргийлэх,
 - d. Орчны агаарын чанарыг ажлын явцад хэмжиж хянах. Тухайлбал ажилтанд зүүлгэсэн хүчилтөрөгч, шатамхай, хорт хий хэмжих багажийг ашиглана.

- e. Орчинд үүсэж болзошгүй живэх, сорогдох даарах, осгох эрсдлийг урьдчилан тооцож ажиллана.
 - f. Шатамхай хий ялгарч болзошгүй орчинд ажиллахдаа цахилгаанждагүй буюу анти статик материалаар хийгдсэн хувцас хэрэгсэл хэрэглэнэ.
- 4) Ажил гүйцэтгэх арга барилыг өөрчилснөөр аюул, эрсдэлийг арилгах, бууруулах боломжтой.
- a. Харьцаж буй бодисын шинж чанар, багаж төхөөрөмж, ажлын төрлөөс хамаарч аль болох аюулгүй арга шийдлийг ашиглах,
 - b. Орчинд тархах агаар бохирдуулагчийн ялгарлыг хамгийн бага хэмжээнд байлгах ажлын арга барилыг хэрэглэх,
 - c. Хязгаарлагдмал орчинд ажиллах хугацааг багасгах,
 - d. Хязгаарлагдмал орчинд нэвтрэх хүний тоог цөөлөх,
 - e. Галын эх үүсвэрийг оруулахгүй, ил гал оч гаргагүй байснаар гал, тэсрэх аюулаас сэргийлэх,
 - f. Цахилгаанаар ажилладаг багаж, төхөөрөмжийн аюулгүй байдлыг хангах,
 - g. Хязгаарлагдмал орчинд нэвтэрсэн ажилтнуудад хий илрүүлэгч багажийг тогтмол зүүлгэж, аюулын дохио өгсөн үед яаралтай гарах,
- 5) Аюултай байж болзошгүй тоног төхөөрөмж, хүчний эх үүсвэр, хий, уур, шингэний урсгал, энерги, ус зэргийг хааж, хязгаарлагдмал орчинд хүн нэвтрэхээс өмнө тусгаарлах цоожлох, пайзлах,
- 6) Эрсдэлийн үнэлгээгээр агаарын чанар аюултай түвшинд байгаа нь тодорхойлогдсон бол агааржуулалт хийх,
- 7) Эрсдлийн үнэлгээгээр шаардлагатай нь тогтоогдвол цэвэрлэгээ, халдваргүйтгэл хийнэ. Цэвэрлэгээ, халдваргүйтгэл хийх ажилтан нь зөвшөөрөл авч, тусгай хувийн хамгаалах хэрэгсэлээр хангагдаж, ХАБЭА-н дүрэм журмыг чанд мөрдөж ажиллана.
- 8) Даралтад болон шингэрүүлсэн хийн цилиндрийг хязгаарлагдмал орчинд ашиглахдаа дараах шаардлагыг хангана.
- a. Агаар нөөцлөгчтэй амьсгалын аппараттаас бусад төрлийн даралтад хийтэй цилиндрийг хязгаарлагдмал орчинд авч орохыг хориглоно.
 - b. Гидралик багажны шингэн дамжуулах хоолойг шалгаж бүрэн бүтэн байдлыг хангана.
 - c. Гидралик багажны дамжуулах хоолойг гэмтэхээс хамгаалж, байрлуулах, зориулалтын газар хадгална.
 - d. Ашиглаагүй үед ажлын бүх багаж төхөөрөмжийг унтраана.
- 9) Зөөврийн цахилгаан багажуудыг хязгаарлагдмал орчин дотор ашиглахдаа дараах зүйлийг анхаарна.
- a. Давхар тусгаарлагдсан,
 - b. Зөөврийн газардуулгын хамгаалалт бүрэн байх,
 - c. Цахилгааны кабелиудыг тээглэх, хавчуулагдах, татагдах аюулгүйгээр байрлуулсан (өлгөсөн) байх шаардлагатай.

12.3 Хязгаарлагдмал орчинд нэвтрэгч болон хянагч ажилтнуудыг тохиромжтой харилцаа холбооны хэрэгслээр хангана.

12.4 Хязгаарлагдмал орчинд нэвтрэгч ажилтан нь аюулгүй ажиллагаа, эрүүл мэндийн журмыг чанд мөрдөж ажиллана. Журмын хэрэгжилтэд хяналт тавих үүргийг нэгж хэлтсийн ахлах ажилтан, эрх бүхий ХАБЭА-н ажилтан хүлээнэ.

12.5 Хянагч ажилтан нь хязгаарлагдах орчинд нэвтэрсэн ажилтантай тохиромжтой хэлбэрээр тогтмол харилцаатай байж, аюулгүй байдалд нь хяналт тавина. Шаардлагатай нөхцөлд онцгой байдлын төлөвлөгөөг хэрэгжүүлнэ.

12.6 Ажилтан хязгаарлагдмал орчин дахь ажлаа дуусгаж гарч ирсний дараа зөвшөөрлийн хуудсанд гарын үсэг зурна. Ажил дууссан талаарх мэдэгдлийг ахлах ажилтнаас эрх бүхий удирдах ажилтанд өгч, хязгаарлагдмал орчинд нэвтрэх зөвшөөрлийг хүчингүй болгуулна.

12.7 Хязгаарлагдмал орчны аюулгүй ажиллагааны зааварчилгаа зөрчигдөж буйг мэдсэн хэн боловч ахлах ажилтан, эрх бүхий ХАБЭА-н ажилтан, эрх бүхий удирдах ажилтан нарын хэн нэгэнд нь мэдэгдэнэ.

13.2 Эрх бүхий ХАБЭА-н ажилтан тухайн ажлын эрсдлийн үнэлгээний үр дүнг шаардлагатай ажилтнуудад зааварчлага хэлбэрээр танилцуулж баримтжуулна.

Арван гурав. Хянагч ажилтны үүрэг

13.1 Эрх бүхий ХАБЭА-н ажилтан хязгаарлагдмал орчны хянагч ажилтныг ахлах ажилтны саналын дагуу томилж, зөвшөөрлийн маягтад тэмдэглэнэ.

13.2 Эрх бүхий ХАБЭА-н ажилтан хянагч ажилтан нь 6.1-6.6-д заасан шаардлагыг хангасан эсэхийг нягтлана.

13.3 Хянагч ажилтан нь зөвхөн зөвшөөрлийн дагуу хязгаарлагдмал орчны гадна ажиллаж нэвтрэгч ажилтны аюулгүй байдалд хяналт тавина.

13.4 Хянагч ажилтан дараах үүрэгтэйгээр хязгаарлагдмал орчны гадна талд үлдэнэ.

- Нэвтрэгч ажилтантай тогтмол холбоотой байж, ажиглалт хийх,
- Нэвтрэгч ажилтныг хязгаарлагдмал орчноос гарахад нь тусална,
- Гадаад орчинд онцгой нөхцөлийн үед нэвтрэгч ажилтанд мэдээлж, гарахад тусална.
- Ослын үед онцгой үеийн төлөвлөгөө хэрэгжүүлнэ.

13.5 Хянагч ажилтан хязгаарлагдмал орчинд нэвтэрсэн ажилтанд хяналт тавьж ажиллах үедээ давхар аливаа ажил үүрэг гүйцэтгэхгүй.

Арван дөрөв. Аврах ажиллагааны ерөнхий зарчим

14.1 Хязгаарлагдмал орчинд нэвтрэх, ажил гүйцэтгэдэг байгууллага нь ослын үед хязгаарлагдмал орчинд ажиллаж буй ажилтныг аврах бичгээр үйлдсэн төлөвлөгөөтэй байх ба үүний бэлэн байдлыг нь тогтмол хангана.

14.2 Эрх бүхий ХАБЭА-н ажилтан нь онцгой үеийн төлөвлөгөөг бичгээр үйлдэж, эрх бүхий удирдах ажилтнаар батлуулна.

14.3 Газар зүйн байршил, үйл ажиллагааны онцлог, эрсдэлийн төрлөөс хамаарч аж ахуйн нэгж байгууллага нь аврах баг, ажилтантай байж болно.

14.4 Аврах ажилтан нь онцгой байдлын мэргэжлийн байгууллагын сургалтад хамрагдаж, осолдогчид анхны тусламж үзүүлэх, хязгаарлагдмал орчинд аврах ажиллагаа явуулах, хувийн хамгаалах хэрэгсэл, аврах ажиллагааны багаж хэрэгслийг хэрэглэх чадамжийг эзэмшсэн байна. Сургалт зохион байгуулсан байгууллага нь аврах ажилтны чадамжийг үнэлж, баталгаажуулна.

14.5 Аврах ажиллагааг хоёр ба түүнээс олон тооны чадамжтай ажилтан гүйцэтгэнэ. Шаардлагатай нөхцөл байдалд мэргэжлийн байгууллагын тусламжийг авна.

14.6 Аврах баг нь аврах ажиллагаанд ашиглах хангалттай тооны, шаардлага хангасан амьсгалын аппарат, аюулгүйн бүс, бэхэлгээ, нөхцөл байдалд тохирсон аврах хэрэгсэл, амилуулах багажтай байна. Эдгээрийн бэлэн байдлыг хангахад дараах шаардлагыг биелүүлнэ.

- Шууд ашиглахад бэлэн байдлыг хангасан,
- Зохих ёсоор техник үйлчилгээнд баталгаажуулалтанд хамрагдсан,
- Сар тутамд нэг ба түүнээс олон удаа аврах ажиллагааны чадамжтай ажилтнаар шалгагдсан байна.

14.7 Аврах ажиллагааны чадамжтай ажилтан нь 14.6-д заасан багаж хэрэгслийн бэлэн, найдвартай байдлыг шалгалтын сар тутамд хийж хийж, тэмдэглэл хөтөлж, тайлан гаргана.

14.8 Онцгой байдлын төлөвлөгөөний бэлэн байдлыг хангах сургуулилтыг сар тутам хийнэ.

14.9 Аврах баг хязгаарлагдмал орчинд нэвтрэхээс өмнө орчны нөхцөл байдалтай сайтар танилцсан байна.

14.10 Ослын үед аврах ажиллагаа явуулах зорилгоор хязгаарлагдмал орчин руу нэвтрэхэд зөвшөөрөл, эрсдэлийн үнэлгээ шаардагдахгүй. Гэхдээ тухайн тохиолдол, нөхцөл байдалтай уялдуулан ажиллах тактикаа маш сайн боловсруулж өөрсдөө аюул осолд өртөхөөс сэргийлж, өндөр сонор сэрэмжтэй ажиллана.

Арван тав. Сургалт

15.1 Энэхүү зааврын хэрэгжилтийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор дараах ажилтнуудыг сургалтад хамруулж, шаардлагатай чадамжийг эзэмшүүлнэ.

- 1) Эрх бүхий удирдах ажилтан
- 2) Эрх бүхий ХАБЭА-н ажилтан
- 3) Хязгаарлагдмал орчинд нэвтрэгч, хянагч, ахлах ажилтнууд,
- 4) Хязгаарлагдмал орчинд аврах ажиллагаа явуулах ажилтан

15.2 Байгууллагын удирдах албан тушаалтан, ХАБЭА-н ажилтан мэргэжлийн байгууллагаас зохион байгуулсан хязгаарлагдмал орчны аюулгүй ажиллагааны мэргэшүүлэх сургалтад хамрагдаж, шаардлагатай чадамжийг эзэмшсэн байна. Мэргэшүүлэх сургалтын онол, дадлагын хичээлийн харьцаа 40:60 байвал зохино.

15.3 Хязгаарлагдмал орчны аюулгүй ажиллагааны мэргэшүүлэх ажилтан, албан тушаалтан нь ХАБЭА-н чиглэлээр их дээд сургууль төгссөн эсвэл ХНХС-ын 2019 оны А/370 тоот тушаалаар батлагдсан хөтөлбөрийн дагуу сургалтад хамрагдсан байна.

15.4 Мэргэшүүлэх сургалтад хамрагдсан, 4.6-д заасан шаардлагыг хангасан эрх бүхий ХАБЭА-н ажилтан нь хязгаарлагдмал орчны нэвтрэгч, хянагч, ахлах ажилтнуудад зориулсан сургалтыг жилд 2-оос доошгүй удаа хийнэ. Байгууллага дотооддоо уг сургалтыг хийх боломжгүй тохиолдолд мэргэжлийн байгууллагаар хийлгэх шаардлагатай.

15.5 Нэвтрэгч, хянагч, ахлах ажилтнуудад зориулсан сургалт нь хязгаарлагдмал орчноос үүсэх аюул, эрсдэлийн шинж чанар, тэдгээрээс урьдчилан сэргийлэхэд

хангалттай түвшний мэдлэг, дадлыг эзэмшүүлэхэд чиглэнэ. Сургалтын онол: дадлагын харьцаа 30:70 байвал зохино.

15.6 Хязгаарлагдмал орчинд нэвтрэгч, хянагч ажилтнуудад үндсэн ажил үүргээ гүйцэтгэх ур чадвар олгох сургалтыг ахлах ажилтан нь хариуцна. Шаардлагатай тохиолдлын мэргэжлийн боловсролын байгууллагаа энэ төрлийг сургалтыг авч болно.

15.7 Хязгаарлагдмал орчинд аврах ажиллагаа явуулах ажилтан нь онцгой байдлын байгууллагаас зохион байгуулсан сургалтад хамрагдаж, шаардлагатай чадамжийг эзэмшсэн байна.

15.8 Хязгаарлагдмал орчны ажлын эхэнд тухайн ажлын онцлогоос хамаарч ажлын байрны зааварчилгаа сургалтыг ярилцлага зөвлөмжийн хэлбэрээр эрсдлийн үнэлгээ, ажиллах зөвшөөрлийг үндэслэн ХАБЭА-н эрх бүхий ажилтан, ахлах ажилтантай хамтран өгч баримтжуулна. Үүнд:

1. Эрсдлийн түвшин өндөр ажилбаруудын тайлбар танилцуулга
2. Ажилд хэрэглэгдэх багаж хэрэгсэл, төхөөрөмжийн ажиллагаа
3. Авралтын төлөвлөгөөний танилцуулга, үүрэг хуваарилалт зэргийг тайлбарлах.

Арван зургаа. Баримт, бүртгэл хөтлөлт

16.1 Энэхүү зааврыг хэрэгжүүлэхтэй холбоотойгаар аж ахуйн нэгж байгууллага дараах бүртгэл, баримтыг 1 жил хүртэл хугацаагаар хадгална.

1. Хязгаарлагдмал орчны бүртгэл,
2. Хязгаарлагдмал орчинд нэвтрэх зөвшөөрөл өгөхөөс өмнө хийсэн эрсдэлийн үнэлгээний тайлан,
3. Хязгаарлагдмал орчинд нэвтрэх зөвшөөрөл,
4. Хязгаарлагдмал орчны аюулгүй ажиллагааны зааварчилгааг хэрэгжүүлэх эрх бүхий удирдах ажилтан, ХАБЭА-н ажилтан, нэвтрэгч, хянагч, ахлах ажилтнууд сургалтын бүртгэл, баримт,
5. Онцгой үеийн төлөвлөгөө, бэлэн байдлыг хангах шалгалт, сургуулилтын тайлан, бүртгэл

Төгсөв.

Хавсралт 1.

ХЯЗГААРЛАГДМАЛ ОРЧИНД НЭВТРЭХ ЗӨВШӨӨРӨЛ

Байгууллагын нэр:		Зөвшөөрөл олгосон огноо:	__он__сар__өдөр
ХО-ны байршил:		Зөвшөөрөл дуусах огноо:	__он__сар__өдөр
ХО-ны тодорхойлолт:			
Нэвтрэх зорилго:			
АГААРЫН ЧАНАРЫН ХЭМЖИЛТ			
Үзүүлэлт	Нэвтрэхээс өмнөх дүн	Явцын хэмжилтийн дүн	
Хүчилтөрөгч (19.5-23.5%)			
Шатамхай хий LEL (<10%)			
Угаарын хий (<25 ppm)			
Хүхэрт устөрөгч (<10 ppm)			
Хорт хий 1:			
Хорт хий 2:			
Нэвтрэхээс өмнөх хэмжилт хийсэн ажилтан:	Овог нэр	Гарын үсэг	Огноо: Цаг: мин
Багажны мэдээлэл	Үйлдвэрлэгч, загвар	Сериал дугаар	Шалгалт тохируулгын огноо
			Хэмжилтээс өмнө тэг шалгалт хийсэн <input type="checkbox"/> тийм <input type="checkbox"/> үгүй
БОХИРДУУЛАГЧ, ХҮЧНИЙ ЭХ ҮҮСВЭРИЙГ САЛГАЖ, ТУСГААРЛАСАН МЭДЭГДЭЛ			
АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ХЯНАЛТЫН ШААРДЛАГАТАЙ АРГА ХЭМЖЭЭ			
	Тийм	Үгүй	Тэмдэглэл
Амьсгал хамгаалах хэрэгсэл			
Хамгаалах хувцас			
Хамгаалалтын дуулга			
Хамгаалах гутал			
Нүдний хамгаалалтын шил			
Хамгаалалтын бээлий			
Бусад ХХХ			
Гал унтраагуур			
Аврах хэрэгсэл			
Түгжих, пайзлах			
Агааржуулалт			
Анхааруулах тэмдэг / хаалт			
Бусад хамгаалах арга хэмжээ:			
Агаарын чанарын явцын хэмжилт			
Харилцаа холбооны хэрэгсэл			
НЭВТРЭГЧ, ХЯНАГЧ АЖИЛТНУУДАД ӨГСӨН ТУСГАЙ ЗААВАРЧИЛГАА			
Нэвтэрсэн ажилтныг ажиглаж, харилцах хэлбэр	<input type="checkbox"/> Харагдах байдлаар	<input type="checkbox"/> Шууд аман харилцаа	<input type="checkbox"/> Радио холбоо <input type="checkbox"/> Телефон
ОНЦГОЙ ҮЕД ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨ			
			Онцгой үед холбогдох утасны дугаар:
ЗӨВШӨӨРӨГДСӨН АЖИЛТНЫ НЭР			
	Нэвтэрсэн цаг: мин	Гарсан цаг: мин	ХО-н гарсан ажилтны гарын үсэг
Нэвтрэгч ажилтны нэр			
Хянагч ажилтны нэр			
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОСОН:		ЗӨВШӨӨРЛИЙГ ЦУЦАЛСАН:	
Овог нэр	Гарын үсэг	Овог нэр	Гарын үсэг
ЗӨВШӨӨРЛИЙГ ХЯНАСАН:			
Овог нэр	Гарын үсэг		